



IAF Заавал мөрдөх баримт бичиг

ТҮҮВЭРЛЭЛТЭНД СУУРИЛЖ ОЛОН САЛБАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ТУХАЙ

Хэвлэл 1, Хувилбар 3

(IAF MD 01:2007)

Хэвлэсэн огноо: 2007.11.20

Хэрэгжиж эхлэх огноо: 2008.09.15

Олон улсын итгэмжлэлийн форум, Inc. (ОУИФ) тохирлын үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг итгэмжлэхэд тавих шалгуурыг нарийвчлан тогтоодог. Итгэмжлэл нь худалдааг хөнгөвчлөх ба тохирлын давхардсан олон гэрчилгээний хэрэгцээ шаардлагыг багасгадаг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагууд (ТҮБ) итгэмжлэлийн хүрээндээ хэрэгжүүлэх ажлаа хийх чадвартайг батлах замаар бизнес эрхлэгчдийн болон хэрэглэгчдийн эрсдэлийг бууруулдаг.

ОУИФ-ийн гишүүн итгэмжлэлийн байгууллага болон тэдгээрийн итгэмжилсэн ТҮБ-ууд нь олон улсын зохих стандарт, эдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулан гарсан ОУИФ-ын баримт бичгийг дагаж мөрдөх шаардлагатай.

ОУИФ Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ОТХХЗХ)-ийн гишүүд итгэмжлэлийн хөтөлбөрийн дагуу харилцан бие биенээ энэ тэнцүү үнэлэх үнэлгээг тогтмол явуулна. ОУИФ ОТХХЗХ нь хоёр түвшинд үйл ажиллагаа явуулна:

- Хяналтын байгууллагад зориулсан ISO/IEC 17020, удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын байгууллагад зориулсан ISO / IEC 17021, ажилтны баталгаажуулалтанд зориулсан ISO / IEC 17024, бүтээгдэхүүний баталгаажуултын байгууллагад зориулсан ISO/IEC Guide 65-ын дагуу хэрэгжүүлж буй хүрээнд ОТХХЗХ -г авч үзнэ. А хүрээний ОТХХЗХ итгэмжлэгдсэн ТҮБ-д итгэх итгэлийг өгч, тохирлын үнэлгээний үйл ажиллагааны гүйцэтгэлд адил найдвартай байна.

- Тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлд тусгай тохирлын үнэлгээний

The International Accreditation Forum, Inc. (IAF) operates programs for the accreditation of bodies that provide conformity assessment services. Such accreditation facilitates trade and reduces demand for multiple certification.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited Conformity Assessment Bodies (CABs) are competent to carry out the work they undertake within their scope of accreditation.

Accreditation Bodies (ABs) which are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

AB members of the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) conduct regular evaluations of each other to assure the equivalence of their accreditation programs. The IAF MLAs operate at two levels:

- A MLA for the accreditation of CABs to standards including ISO/IEC 17020 for inspection bodies, ISO/IEC 17021 for management systems certification bodies, ISO/IEC 17024 for personnel certification bodies and ISO/IEC Guide 65 for product certification bodies, is considered a framework MLA. A framework MLA provides confidence that accredited CABs are equally reliable in the performance of conformity assessment activities.

- A MLA for the accreditation of CABs that also includes the specific conformity

стандарт эсвэл баталгаажуулалтын ижил түвшинд итгэл өгөх итгэмжлэлийн хүрээ гэх мэт схемүүдийг багтаана.

ОУИФ ОТХХЗХ нь баталгаажуулалтыг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг бий болгоно. Тодорхой стандарт буюу схемийн гэрчилгээтэй байгууллага буюу хувь хүн IAF MLA-д гарын үсэг зурсан итгэмжлэлийн байгууллага дэлхий даяар олон улсын худалдааг хөнгөвчлөхөд хүлээн зөвшөөрч болно.

Хэвлэл No 1

Боловсруулсан: IAF Техникийн хороо

Баталсан: IAF гишүүд, огноо: 11 October 2007

Хэвлэсэн огноо: 20 November 2007

Хэрэгжиж эхлэх: 15 September 2008

Жон Оуэн, ОУИФ корпорацийн нарийн бичгийн дарга

Холбоо барих: Утас: +612 9481 7343;

И-мэйл: secretary1@iaf.nu

assessment standard or scheme as a scope of accreditation provides confidence in the equivalence of certification.

An IAF MLA delivers the confidence needed for market acceptance of certification. An organization or person with certification to a specific standard or scheme that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide thereby facilitating international trade.

Issue No 1

Prepared by: IAF Technical Committee

Approved by: IAF Members Date: 11 October 2007

Issue Date: 20 November 2007 Application Date: 15 September 2008

Name for Enquiries: John Owen, IAF Corporate Secretary

Contact: Phone: +612 9481 7343;

Email: secretary1@iaf.nu

IAF-ийн заавал мөрдөх баримт бичгийн танилцуулга

Энэ баримт бичигт хэрэглэгдэх "байвал зохино" нэр томъёо нь стандартын шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ.

Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллага (ИБ)-д нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх "байх ёстой" нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

Introduction to IAF Mandatory Documents

The term "should" is used in this document to indicate recognized means of meeting the requirements of the standard.

A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term "shall" is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

Түүвэрлэлтэд үндэслэн олон газарт баталгаажуулалт хийхэд заавал мөрдөх ОУИФ баримт бичиг

Энэхүү баримт бичиг нь IAF GD2:2005-ын хавсралт 3-т заасан арга зүйн удирдамж, G.5.3.5-G.5.3.13 заалтуудад үндэслэгдсэн бөгөөд ISO/IEC 17021:2006 стандартын 9.1.5 бүлгийг тууштай хэрэглэхэд заавал мөрдөнө.

ISO / IEC 17021: 2006-ын бүх заалтыг үргэлжлүүлэн хэрэглэх ба энэ баримт бичиг тухайн стандартын ямар нэгэн шаардлагыг орлохгүй.

Энэхүү заавал мөрдөх баримт бичгийг зөвхөн чанарын менежментийн тогтолцоо (ЧМТ), байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ)-нд бус бусад менежментийн тогтолцоонд ашиглаж болно.

Гэсэн хэдий ч холбогдох стандартуудаар олон салбарт дээж авах эсвэл дээж авахгүй тухай тусгай шаардлагуудыг заасан байж болно (жишээ нь. ISO / IEC 27006, ISO / TS 22003).

0. ТАНИЛЦУУЛГА

0.1. Энэхүү баримт бичгийг аудит хийхэд зориулсан бөгөөд зохимжтой нөхцөлд сүлжээ газруудтай байгууллагын менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг холбогдох стандартад нийцтэйгээр, нэрлэгдсэн бүх салбарт хангалттай итгэлтэй хийж байгаа эсэхийг болон аудит нь эдийн засгийн болон үйл ажиллагааны хувьд хэрэгжиж болохуйц, тохиромжтой байхыг харуулна.

0.2. Ерөнхийдөө баталгаажуулалтын анхдагч аудит, магадлан хяналт, давтан батлагаажуулалтыг байгууллагын баталгаажуулалтад хамрагдах бүх

IAF Mandatory Document for the Certification of Multiple Sites Based on Sampling

This document is mandatory for the consistent application of Clause 9.1.5. of ISO/IEC17021:2006 and is based upon guidance previously provided in IAF GD2: 2005 Annex 3 and IAF GD6:2003, clause G.5.3.5 – G.5.3.13.

All clauses of ISO/IEC 17021:2006 continue to apply and this document does not supersede any of the requirements in that standard.

This mandatory document is not exclusively for Quality Management Systems (QMS) and Environmental Management Systems (EMS) and may be used for other management systems.

However, relevant standards may provide specific requirements for multiple sites or preclude the use of sampling (eg. ISO/IEC 27006, ISO/TS 22003).

0. INTRODUCTION

0.1. This document is for the audit and, if appropriate, the certification of management systems in organizations with a network of sites to ensure that the audit provides adequate confidence in the conformity of the management system to the relevant standard across all sites listed and that the audit is both practical and feasible in economic and operative terms.

0.2. Normally initial audits for certification and subsequent surveillance and recertification audits should take place at every site of the organization that is to be

салбарт хийх ёстой.

Харин байгууллагын баталгаажуулалтад хамрагдах үйл ажиллагаа өөр өөр байранд, ижил аргаар, бүгд байгууллагын удирдлага ба хяналтан дор явагддаг бол баталгаажуулалтын байгууллага нь анхдагч аудит, дараа дараагийн магадлан хяналт болон давтан баталгаажуулалтанд байруудыг түүвэрлэхийн тулд тохирох журам боловсруулна.

Энэхүү баримт бичигт түүврийн хэмжээ, аудитын үргэлжлэх хугацаа болон итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагад хүлээн зөвшөөрөгдөх боломжтой нөхцлийг тусгасан.

0.3. Энэхүү баримт бичиг олон салбарт нь ижил менежментийн тогтолцоон дор өөр өөр эсвэл хэд хэдэн байранд ялгаатай үйл явц, үйл ажиллагаа явагддаг байгууллагын аудитын үйл ажиллагаанд хамаарахгүй. Дээрх нөхцөлд баталгаажуулалтын байгууллага бүх салбарт хийх ердийн бүтэн аудитыг багасгаж болох ба багасгах нөхцөл нь багасгах санал гаргасан салбар бүрт үндэслэлтэй байх ёстой.

0.4. Энэхүү баримт бичиг олон салбартай байгууллагыг түүвэрлэлт ашиглан баталгаажуулдаг, аудит хийдэг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагад үйлчилнэ. Гэхдээ итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага энэхүү баримт бичгийн нөхцлөөс хазайсан бол холбогдох үндэслэлээ гаргаж болно. Итгэмжлэлийн байгууллага уг үндэслэлийг шалгахад бүх газруудын менежментийн тогтолцооны тохиролтой нь ижил түвшний найдвартай байх ёстой.

covered by the certification.

However, where an organization's activity subject to certification is carried out in a similar manner at different sites, all under the organization's authority and control, a certification body may put into operation appropriate procedures for sampling the sites at the initial audit and subsequent surveillance and recertification audits.

This document addresses the conditions under which this is acceptable for accredited certification bodies including the calculation of sample size and audit duration.

0.3. This document does not apply to the audits of organizations that have multi-sites where fundamentally dissimilar processes or activities are used at the different sites, or a combination of sites, even though they may be under the same management system. The conditions under which certification bodies can make any reduction in the normal full audit of every site in these circumstances have to be justified at each site where a reduction is proposed.

0.4. This document is applicable to accredited certification bodies that employ sampling in their audit and certification of multi-site organizations. Nevertheless an accredited certification body may exceptionally deviate from this document under condition it is able to produce relevant justifications. These justifications shall, under evaluation by the accreditation body, demonstrate that the same level of confidence in the conformity of the management system across all the sites listed can be obtained.

0.5. Тухайн байгууллага түүвэрлэх аргад суурилсан баталгаажуулалтын ажиллагаанд оролцох гэж байгаа бол баталгаажуулалтын байгууллага аудит эхлэхээс өмнө энэ баримт бичгийг хэрэглэх талаар тайлбарлах арга хэмжээ авах ёстой.

1. ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Байгууллага

Энэ нэр томъёо нь аудит болон баталгаажуулалтад хамаарах менежментийн тогтолцоог эзэмшиж буй аливаа компани, өөр бусад байгууллагыг тодорхойлно.

1.2 Салбар

Салбар гэж тодорхой байгууллагын ажил, үйлчилгээ явуулж байгаа байнгын байрлал юм.

1.3 Түр байр

Түр байр гэдэг нь хязгаарлагдмал цаг хугацаанд тодорхой нэг ажил үйлчилгээ гүйцэтгэхийн тулд байгууллагаас гаргасан байр бөгөөд байнгын байр биш юм. (барилгын талбай г.м).

1.4 Нэмэлт салбар

Олон салбартай гэрчилгээжсэн сүлжээнд нэмэгдэж буй шинэ салбар, бүлэг салбар.

1.5 Олон салбартай байгууллага

Олон салбартай байгууллага гэдэг нь үйл ажиллагааг төлөвлөж, хянаж, удирддаг тодорхой төвтэй (цаашид төв оффисд хамаарах - заавал байгууллагын удирдах төв байр байх албагүй) байгууллага болон дээрх үйл ажиллагаа бүрэн эсвэл хэсэгчлэн гүйцэтгэгддэг хязгаарлагдмал оффис эсвэл салбаруудын нэгдсэн сүлжээ.

0.5. When an organization is considered a candidate for certification based on sampling, the certification body shall have arrangements to explain the application of this document to the organization prior to the commencement of the audit.

1. DEFINITIONS

1.1. Organization

The term organization is used to designate any company or other organization owning a management system subject to audit and certification.

1.2. Site

A site is a permanent location where an organization carries out work or a service.

1.3. Temporary Site

A temporary site is one set up by an organization in order to perform specific work or a service for a finite period of time and which will not become a permanent site. (eg.construction site).

1.4. Additional Sites

A new site or group of sites that will be added to an existing certified multi-site network.

1.5. Multi-site Organization

A multi-site organization is defined as an organization having an identified central function (hereafter referred to as a central office – but not necessarily the headquarters of the organization) at which certain activities are planned, controlled or managed and a network of local offices or branches (sites) at which such activities are fully or partially carried out.

2.ХЭРЭГЛЭЭ

2.1 Салбар

2.1.1 Салбар гэдэг нь өгөгдсөн байрлалд байгаа байгууллагын хяналтан дор үйл ажиллагаа явагдаж байгаа, түүнд ашиглагдаж буй холбогдох түүхий эд материалын агуулах, дайвар бүтээгдэхүүн, завсрын бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүн, хаягдал материал болон үйл ажиллагаанд холбогдох дэд бүтэц, тоног төхөөрөмж зэрэг байгаа бүх газар юм. Тогтмол эсэх нь үл хамаарна.

Эсвэл хуульд заасан тохиолдолд, үндэсний болон орон нутгийн тусгай зөвшөөрөл олгох дүрэм журамд заасан тодорхойлолтыг хэрэглэнэ.

2.1.2 Байршлийг тодорхойлох боломжгүй бол (ж нь: үйлчилгээнд) баталгаажуулалтын хамрах хүрээнд удирдах төв байрны үйл ажиллагааг үйлчилгээтэй нь нэгэн адил авч үзвэл зохино.

Зайлшгүй нөхцөлд баталгаажуулалтын байгууллага баталгаажуулалтын аудитыг зөвхөн үйлчилгээ явуулдаг газарт гүйцэтгэхээр шийдвэрлэж болно. Ийм тохиолдолд төв байртай харилцах бүх хэсгүүдийг тодорхойлж, аудит хийх ёстой.

2.2. Түр байр

2.2.1 Менежментийн тогтолцооны үйл ажиллагаа, үр дүнг нотлох баримтаар хангахын тулд байгууллагын менежментийн тогтолцоонд багтах түр байруудад түүвэрлэлтэд суурилсан аудит хийж болзошгүй. Түр байрууд нь харин баталгаажуулалтын байгууллага болон үйлчлүүлэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу олон салбарт хийх баталгаажуулалтын хамрах хүрээнд багтаж болно. Хамрах хүрээнд багтах бол ийм салбаруудыг түр байр гэж тодорхойлох ёстой.

2. APPLICATION

2.1. Site

2.1.1. A site could include all land on which activities under the control of an organization at a given location are carried out including any connected or associated storage of raw materials, by-products, intermediate products, end products and waste material, and any equipment or infrastructure involved in the activities, whether or not fixed.

Alternatively, where required by law, definitions laid down in national or local licensing regimes shall apply.

2.1.2. Where it is not practicable to define a location (e.g. for services), the coverage of the certification should take into account the organization's headquarters activities as well as delivery of its services.

Where relevant, the certification body may decide that the certification audit will be carried out only where the organization delivers its services. In such cases all the interfaces with its central office shall be identified and audited.

2.2. Temporary Site

2.2.1. Temporary sites that are covered by the organization's management system may be subject to audit on a sample basis to provide evidence of the operation and effectiveness of the management system. They may, however be included within the scope of a multisite certification subject to agreement between the certification body and the client organization. Where included in the scope, such sites shall be identified as temporary.

2.3 Олон салбартай байгууллага

2.3.1 Олон салбартай байгууллага онцгой хуулийн этгээд байх шаардлагагүй боловч бүх салбар нь байгууллагын төв оффистой эрх зүй эсвэл гэрээгээр холбоотой байх, бат тогтсон менежментийн тогтолцоотой байх, төв оффисоос байнгын магадлан хяналт, дотоод аудит хийж гүйцэтгэдэг байх ёстой. Өөрөөр хэлбэл төв оффис аль нэг салбарыг шаардлагатай залруулах ажиллагаа хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй гэсэн үг юм.

Хэрэгжүүлэх боломжтой нөхцөлд дээрх зүйлсийг төв оффис болон салбар хоорондын албан ёсны гэрээнд тусгавал зохино.

Олон салбартай байгууллагын жишээ:

- Франчайзтай байгууллага
- Борлуулалтын сүлжээ оффис бүхий үйлдвэрлэлийн компаниуд (энэ баримт бичгийг борлуулалтын сүлжээнд хэрэглэж болно)
- Ижил төстэй үйлчилгээг санал болгож буй олон салбартай үйлчилгээний компаниуд

3. БАЙГУУЛЛАГЫГ ТҮҮВЭРЛЭЛТЭД СОНГОХ

3.0.1 Бүх салбаруудын үйл явц мөн чанартаа нэг төрлийнх байх ба ижил арга, журмаар гүйцэтгэх ёстой. Ижил боловч цөөн үйл ажиллагаата зарим салбаруудыг олон салбарт баталгаажуулалтад багтаж болзошгүй, харин хамгийн олон эсвэл шийдвэрлэх үйл явцыг хэрэгжүүлдэг салбарууд бүрэн аудитад хамрагдана.

2.3. Multi-site Organization

2.3.1. A multi-site organization need not be a unique legal entity, but all sites shall have a legal or contractual link with the central office of the organization and be subject to a common management system, which is laid down, established and subject to continuous surveillance and internal audits by the central office. This means that the central office has rights to require that the sites implement corrective actions when needed in any site.

Where applicable this should be set out in the formal agreement between the central office and the sites.

Examples of possible multi-site organizations are:

- Organizations operating with franchises
- Manufacturing companies with a network of sales offices (this document would apply to the sales network)
- Service companies with multiple sites offering a similar service

3. ELIGIBILITY OF AN ORGANIZATION FOR SAMPLING

3.0.1 The processes at all the sites have to be substantially of the same kind and have to be operated to similar methods and procedures. Where some of the sites under consideration conduct similar, but fewer processes than others, they may be eligible for inclusion under multi-site certification providing that the sites(s) which conduct the most processes, or critical processes are subject to full audit.

3.0.2 Холбоотой үйл явцаар янз бүрийн байршилд ажлаа явуулдаг байгууллагууд энэхүү баримт бичгийн бусад бүх заалтад нийцсэн тохиолдолд түүвэрлэлтэд сонгогдох эрхтэй болно. Байршил бүр дэх үйл явц ижил биш боловч тодорхой холбоотой байвал түүвэрлэлтийн төлөвлөгөөнд байгууллагын гүйцэтгэдэг үйл явц бүрээс дорж хаяж нэг жишээг оруулах ёстой (ж нь: электрон бүрдэл хэсгүүдийн үйлдвэрлэл, тухайн бүрдэл хэсгүүдийн угсралт зэргийг нэг компани хэд хэдэн өөр байршилд гүйцэтгэх).

3.0.3 Байгууллагын менежментийн тогтолцоо төвлөрсөн хяналттай, удирдлагын төлөвлөгөөтэй, төв менежментийн дүн шинжилгээтэй байх ёстой. Холбогдох бүх газрууд (захиргааны төв үйл ажиллагаа гэх мэт) байгууллагын дотоод аудитын хөтөлбөрт багтсан байх ёстой бөгөөд баталгаажуулалтын байгууллагын аудит эхлэхээс өмнө тухайн хөтөлбөрийн дагуу аудит хийсэн байх ёстой.

3.0.4 Тухайн байгууллагын төв оффис холбогдох менежментийн тогтолцооны стандартын дагуу менежментийн тогтолцоог нэвтрүүлж, стандартын шаардлагыг бүхэлдээ хангасан гэдгээ батлан харуулах ёстой. Ингэхдээ холбогдох дүрэм, журмыг харгалзан үзэх ёстой.

3.0.5 Байгууллага бүх салбар, төв оффис, түүний удирдлагаас мэдээлэл (доор жагсаасан зүйлсээр хязгаарлагдахгүй) цуглуулах, түүндээ задлан шинжилгээ хийх чадвар ба шаардлагатай нөхцөлд зохион байгуулалтын өөрчлөлтийг эхлүүлэх эрх мэдэл, чадвартай гэдгээ батлан харуулвал зохино:

- Тогтолцооны баримтжуулалт,

3.0.2 Organizations which conduct their business through linked processes in different locations are also eligible for sampling providing all other provisions of this document are met. Where processes in each location are not similar but are clearly linked, the sampling plan shall include at least one example of each process conducted by the organization (eg. fabrication of electronic components in one location, assembly of the same components – by the same company in several other locations).

3.0.3 The organization's management system shall be under a centrally controlled and administered plan and be subject to central management review. All the relevant sites (including the central administration function) shall be subject to the organization's internal audit program and all shall have been audited in accordance with that program prior to the certification body starting its audit.

3.0.4 It shall be demonstrated that the central office of the organization has established a management system in accordance with the relevant management system standard under audit and that the whole organization meets the requirements of the standard. This shall include consideration of relevant regulations.

3.0.5 The organization should demonstrate its ability to collect and analyze data (including but not limited to the items listed below) from all sites including the central office and its authority and also demonstrate its authority and ability to initiate organizational change if required:

- System documentation and system

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • тогтолцооны өөрчлөлт • Удирдлагын дүн шинжилгээ • Гомдол • Залруулах ажиллагааны үнэлгээ • Дотоод аудитын төлөвлөлт, үр дүнгийн үнэлгээ • Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ)-нд холбогдох нөлөө, хэтийн төлвийн өөрчлөлт • Янз бүрийн эрх зүйн шаардлагууд | <ul style="list-style-type: none"> • changes; • Management review; • Complaints; • Evaluation of corrective actions; • Internal audit planning and evaluation of the results; • Changes to aspects and associated impacts for environmental management systems (EMS) • Different legal requirements. |
|---|---|

3.0.6 “Олон салбартай байгууллага” ангилалд багтах бүх байгууллага түүвэрлэлтэнд сонгогдох эрхтэй биш.

3.0.6 Not all organizations fulfilling the definition of “multi-site organization” will be eligible for sampling.

3.0.7 Олон салбартай баталгаажуулалт хийхэд менежментийн тогтолцооны бүх стандарт тохиромжтой биш. Жишээ нь, стандарт нь дотоод тогтворгүй хүчин зүйлсд аудит хийхийг шаарддаг бол энэ стандартаар түүвэрлэлт хийхэд тохиромжгүй болно. Автомашину (TS 16949) болон нисэхийн (9100 цуврал AS) зэрэг зарим схемд нарийвчилсан дүрэм үйлчилдэг бөгөөд ийм схемийн шаардлагыг дагаж мөрдөх ёстой.

3.0.7 Not all management systems standards are suitable for consideration for multi-site certification. For example, multi-site sampling would be unsuitable where the audit of variable local factors is a requirement of the standard. Specific rules apply also for some schemes, for example those including automotive (TS 16949) and aerospace (AS 9100 series) and the requirements of such schemes shall take precedence.

3.0.8 Аудитын үеэр тухайн менежментийн тогтолцооны үр нөлөөтэй байдалд хангалттай итгэлтэй болохын тулд түүвэрлэлт хийх нь тохиромжгүй бол баталгаажуулалтын байгууллага ийм түүвэрлэлтийг хязгаарлах баримтжуулсан журамтай байвал зохино. Баталгаажуулалтын байгууллага ийм хязгаарлалтыг доорх зүйлсийг харгалзан үзэж тодорхойлно. Үүнд:

3.0.8 Certification bodies should have documented procedures to restrict such sampling where site sampling is inappropriate to gain sufficient confidence in the effectiveness of the management system under audit. Such restrictions should be defined by the certification body with respect to:

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • Хамрах сектор, үйл ажиллагаа (тухайн сектор, үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, нарийн төвөгтэй байдлын үнэлгээнд суурилсан), • Олон салбарын аудитад хийх боломжтой салбаруудын хэмжээ; | <ul style="list-style-type: none"> • Scope sectors or activities (i.e. based on the assessment of risks or complexity associated with that sector or activity) • Size of sites eligible for multi-site audit; |
|---|---|

- Янз бүрийн үйл ажиллагаа, гэрээ эсвэл зохицуулалтын тогтолцоог шийдвэрлэхийн тулд менежментийн тогтолцоо доторхи төлөвлөгөөг ашиглахад байнгын тусламж хэрэгцээтэй байх г.м менежментийн тогтолцооны дотоод хэрэгжилтийн хувилбарууд
- Байгууллагын менежментийн тогтолцооны хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа түр байрны ашиглалт. Энэ нь баталгаажуулалтыг хамрах хүрээнд орохгүй.
- Variations in the local implementation of the management system such as the need for frequent recourse to the use of plans within the management system to address different activities or different contractual or regulatory systems;
- Use of temporary sites that operate under the management system of the organization and which are not to be included within the scope of certification.

4. БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

4.0.1 Баталгаажуулалтын байгууллага аудитын үйл ажиллагааг эхлэхээс өмнө тухайн байгууллагыг холбогдох менежментийн тогтолцооны стандартууд, энэхүү баримт бичгийг хэрэглэх талаар мэдээллээр хангах ба хэрэв аль нэг заалтыг хангахгүй бол цааш үргэлжлүүлэхгүй. Баталгаажуулалтын байгууллага анхдагч аудитаар үл тохирол илрүүлвэл гэрчилгээ олгохгүй тухай аудитын үйл явц эхлэхээс өмнө тухайн байгууллагад мэдээлэх ёстой.

4.1 Гэрээний хяналт

4.1.1 Баталгаажуулалтын байгууллагын журамд гэрээний анхны хяналтаар баталгаажуулалтанд оролцох менежментийн тогтолцоонд хамаарах үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал, хэмжээ ба түүвэрлэлтийн түвшинг тодорхойлох үндэс болох салбаруудын хоорондын ялгааг тодорхойлох тухай заасан байвал зохино.

4.1.2 Баталгаажуулалтын үйл ажиллагаанд бэлдэхийн тулд хуулийн дагуу гэрээ байгуулсан байгууллагын голлох үйл ажиллагааг

4. RESPONSIBILITY OF THE CERTIFICATION BODY

4.0.1. The certification body shall provide information to the organization about the application of this document and the relevant management system standards before starting the audit process, and should not proceed if any of the provisions are not met. Before starting the audit process, the certification body should inform the organization that the certificate will not be issued if during an initial audit nonconformities are found.

4.1. Contract Review

4.1.1. The certification body's procedures should ensure that the initial contract review identifies the complexity and scale of the activities covered by the management system subject to certification and any differences between sites as the basis for determining the level of sampling.

4.1.2. The certification body shall identify the central function of the organization with which it has a legally enforceable agreement for the provision of certification activities.

баталгаажуулалтын байгууллага тодорхойлвол зохино.

4.1.3 Баталгаажуулалтын байгууллага тохиолдол тус бүрийн хувьд байгууллагын салбарууд ямар цар хүрээнд ижил журам, аргачлалын дагуу үндсэндээ ижил төрлийн үйл ажиллагааг явуулж байгааг шалгана.

Цөөн боловч бусад салбараас ижил төстэй үйл явцтай салбаруудын хувьд “3.0.1 заалт”, холбоотой үйл явцтай салбаруудын хувьд “3.0.2 заалт”-ыг үзнэ үү.

Баталгаажуулалтын байгууллага шалгалт явуулаад олон-салбарт баталгаажуулалтад оролцохоор санал гаргасан бүх салбарыг оролцох боломжтой гэсэн эерэг дүгнэлт гаргасаны дараагаар л салбар тус бүрт түүвэрлэлтийн журмыг хэрэгжүүлэх боломжтой.

4.1.4 Байгууллагын баталгаажуулалтанд хамрагдах үйл ажиллагаа явагддаг бүх салбарууд нэг дор баталгаажуулалтад хамрагдахад бэлэн биш байгаа бол байгууллага баталгаажуулалтанд хамрагдах болон хамрагдахгүй салбаруудын талаар баталгаажуулалтын байгууллагад урьдчилж мэдээлэх ёстой.

4.2 Аудит

4.2.1 Баталгаажуулалтын байгууллага олон салбартай аудитыг хийх тухай баримтжуулсан журамтай байна.

Баталгаажуулалтын байгууллага энэ журмаар бүх үйл ажиллагааг удирддаг менежментийн нэг тогтолцоо нь үнэхээр бүх салбарт үйлчилж байгаа эсэхийг, мөн энэ баримт бичгийн 3-р бүлэгт заасан бүх шалгуурыг хангасан эсэхийг шалгах боломжийг бүрдүүлнэ.

4.1.3. The certification body shall check, in each individual case, to what extent sites of an organization operate substantially the same kind of processes according to the same procedures and methods.

See clause 3.0.1 for sites which conduct fewer, but similar processes than other sites and clause 3.0.2 for sites involving linked processes.

Only after a positive examination by the certification body that all the sites proposed for inclusion in the multi-site exercise meet the eligibility provisions may the sampling procedure be applied to the individual sites.

4.1.4. If all the sites of a service organization where the activity subject to certification is performed are not ready to be submitted for certification at the same time, the organization shall be required to inform the certification body in advance of the sites that it wants to be included in the certification and those which are to be excluded.

4.2. Audit

4.2.1. The certification body shall have documented procedures to deal with audits under its multi-site procedure.

Such procedures shall establish the way the certification body satisfies itself that the same management system governs the activities at all the sites, is actually applied to all the sites and that all the eligibility criteria for the organization in clause 3 above are met.

Энэ шаардлага цахим баримт бичиг, үйл явцын хяналт болон бусад цахим үйл ажиллагааг ашигладаг менежментийн тогтолцоонд мөн адил үйлчилнэ. Баталгаажуулалтын байгууллага олон салбарын аргыг хэрэгжүүлэхдээ ингэх болсон үндэслэлээ тайлбарлаж бүртгэлжүүлэх ёстой.

This requirement also applies to a management system where electronic documents, process control or other electronic processes are used. The certification body shall justify and record the rationale for proceeding with a multi-site approach.

4.2.2 Сүлжээний аудит, магадлан хяналтад нэгээс дээш аудитын баг оролцвол баталгаажуулалтын байгууллага аудитын бүх багийн үр дүнг нэгтгэж, нэгдсэн тайлан гаргах үүрэг бүхий аудитын онцгой ахлагчийг томилвол зохино.

4.2.2. If more than one audit team is involved in the audit or surveillance of the network, the certification body should designate a unique audit leader whose responsibility is to consolidate the findings from all the audit teams and to produce a synthesis report.

4.3 Үл тохирол

4.3. Nonconformities

4.3.1. Байгууллагын дотоод аудит, баталгаажуулалтын байгууллагын аудитаар аливаа бие даасан салбарт ISO / IEC 17021 стандартын 9.1.15 (b) заалтаар тодорхойлсон үл тохирол илэрвэл бусад салбарт нөлөөлсөн эсэхийг илрүүлэх шалгалт явуулвал зохино. Тиймээс баталгаажуулалтын байгууллага тухайн илэрсэн үл тохирол бүхэл тогтолцооны дутагдалыг илэрхийлж, бусад салбарт нөлөөлсөн эсэхд дүн шинжилгээ хийхийг тухайн байгууллагаас шаардвал зохино. Хэрэв тийм байвал төв оффис болон нөлөөлсөн салбаруудын аль алинд залруулах арга хэмжээ авч, шалгана. Хэрэв үгүй байвал тухайн байгууллага баталгаажуулалтын байгууллагын дагалдан залруулах арга хэмжээг хязгаарлах үндэслэлээ нотлон харуулвал зохино.

4.3.1. When nonconformities, as defined in ISO/IEC 17021 clause 9.1.15 (b), are found at any individual site, either through the organization's internal auditing or from auditing by the certification body, investigation should take place to determine whether the other sites may be affected. Therefore, the certification body should require the organization to review the nonconformities to determine whether they indicate an overall system deficiency applicable to other sites or not. If they are found to do so, corrective action =should be performed and verified both at the central office and at the individual affected sites. If they are found not to do so, the organization should be able to demonstrate to the certification body the justification for limiting its follow-up corrective action.

4.3.2 Баталгаажуулалтын байгууллага эдгээр арга хэмжээний нотлох баримтыг шаардаж, хангалттай хяналт дахин тогтсон гэж үзэх хүртэлээ түүвэрлэлтийн давтамж ба/эсвэл хэмжээг нэмэгдүүлэх ёстой.

4.3.2. The certification body shall require evidence of these actions and increase its sampling frequency and/or the size of sample until it is satisfied that control is re-established.

4.3.3 Шийдвэр гаргах үйл явцын үед аль нэг салбар ISO / IEC 17021 стандартын 9.1.15 (б)-д тодорхойлсон үл тохиролтой байвал хангалттай залруулах арга хэмжээ хүлээгдэж буй энэхүү салбаруудын сүлжээг бүхэлд нь баталгаажуулахаас татгалзах ёстой.

4.3.4 Байгууллага ганц салбарт нь гарсан үл тохирлоос үүдсэн саадыг давахын тулд асуудалтай салбарыг хамрах хүрээнээс хасах боломжгүй. Зөвхөн урьдчилан тохиролцсоны дагуу ингэж хасч болно (4.1.4-р заалтыг үзнэ үү).

4.4. Баталгаажуулалтын баримт бичиг

4.4.1 Баталгаажуулалтын баримт бичгийг баталгаажуулалтын хамрах хүрээнд багтсан, тус бүрдээ энэхүү баримт бичигт заасан түүвэрлэлтийн аргаар гүйцэтгэсэн эсвэл баталгаажуулалтын байгууллагын гүйцэтгэсэн аудитад хамрагдсан хэд хэдэн салбарыг хамруулан гаргаж болно

4.4.2 Баталгаажуулалтын байгууллага гэрчилгээжсэн үйлчлүүлэгчдээ баталгаажуулалтын баримт бичгийг дурын аргаар олгоно. Ийм баталгаажуулалтын баримт бичиг ISO/IEC 17021 стандартай бүх талаараа нийцэх ёстой.

4.4.3 Эдгээр баримт бичгүүд байгууллагын төв оффисын нэр, хаяг болон уг баталгаажуулалтын баримт бичигтэй холбогдох бүх салбаруудын жагсаалтыг агуулсан байна. Эдгээр баримт бичгүүд дэх хамрах хүрээ, тайлбарууд нь баталгаажсан үйл ажиллагааг жагсаалтад заасан сүлжээ салбарууд гүйцэтгэдэг талаар тодорхой заах ёстой. Хэрэв салбарын баталгаажуулалтын хүрээг байгууллагын ерөнхий хүрээний нэг хэсэг шиг

4.3.3. At the time of the decision making process, if any site has a nonconformity, as defined in ISO/IEC 17021 clause 9.1.15 (b), certification shall be denied to the whole network of listed sites pending satisfactory corrective action.

4.3.4. It shall not be admissible that, in order to overcome the obstacle raised by the existence of a nonconformity at a single site, the organization seeks to exclude from the scope the "problematic" site during the certification process. Such exclusion can only be agreed in advance (See clause 4.1.4).

4.4. Certification Documents

4.4.1. Certification documents can be issued covering multiple sites provided that each site included in the scope of certification has either been individually audited by the certification body or audited using the sample approach outlined in this document.

4.4.2. The certification body shall provide certification documents to the certified client by any means it chooses. Such certification documents shall comply in all respects with ISO/IEC 17021.

4.4.3. These documents shall contain the name and address of the central office of the organization and a list of all the sites to which the certification documents relate. The scope or other reference on these documents shall make clear that the certified activities are performed by the network of sites on the list. If the certification scope of the sites is only issued as part of the general scope of the organization, its applicability to all the sites shall be clearly stated. Where temporary sites are included

байдлаар гаргасан бол бүх салбаруудад үйлчлэх эсэхийг тодорхой тусгана. Түр байрууд хүрээнд багтсан бол баталгаажуулалтын баримт бичигт тухайн байрыг түр зуурын гэдгийг тодорхойлох ёстой.

4.4.4 Баталгаажуулалтын баримт бичгүүд нь ижил хүрээ эсвэл нэг хүрээний ижил дэд хүрээг агуулсан бөгөөд баталгаажуулалтын үндсэн баримт бичгүүдэд тодорхой тайлбар оруулсан нөхцөлд баталгаажуулалтанд хамрагдах салбар бүрт зориулсан баталгаажуулалтын баримт бичгийг байгууллагад гаргаж болно.

4.4.5 Хэрэв байгууллагын төв оффис эсвэл аль нэг салбар баталгаажуулалтыг ашиглахад шаардлагатай заалтуудыг биелүүлж чадахгүй бол баталгаажуулалтын баримт бичгүүдийг нийтэд нь эргүүлэн татна.

4.4.6 Салбаруудын жагсаалтыг баталгаажуулалтын байгууллага байнга шинэчилж байх ёстой. Энэ зорилгоор баталгаажуулалтын байгууллага тухайн байгууллагын баталгаажуулалтад хамрагдсан салбарууд хаагдвал тухай бүрт мэдээлэхийг шаардаж байх ёстой. Байгууллага энэ мэдээллийг ирүүлээгүй бол гэрчилгээг зохисгүй ашиглаж байна гэж үзээд холбогдох журмын дагуу арга хэмжээ авч ажиллавал зохино.

4.4.7 Магадлан хяналт, давтан батлагаажуулалт, хамрах хүрээг өргөтгөх үйл ажиллагаагаар одоо байгаа гэрчилгээндээ шинэ салбар нэмж болно. Баталгаажуулалтын байгууллага шинэ салбар нэмэх тухай баримтжуулсан журамтай байх ёстой.

5. Түүвэрлэлт

5.1 Арга зүй

5.1.1 Түүврийг дор дурдсан хүчин зүйлсд

in the scope, such sites shall be identified as temporary in the certification documents.

4.4.4. Certification documents may be issued to the organization for each site covered by the certification under condition that they contain the same scope, or a sub-scope of that scope, and include a clear reference to the main certification documents.

4.4.5. The certification documentation will be withdrawn in its entirety, if the central office or any of the sites does not fulfil the necessary provisions for the maintenance of the certification.

4.4.6. The list of sites shall be kept updated by the certification body. To this effect, the certification body shall request the organization to inform it about the closure of any of the sites covered by the certification. Failure to provide such information will be considered by the certification body as a misuse of the certification, and it should act consequently according to its procedures.

4.4.7. Additional sites can be added to an existing certification as the result of surveillance or recertification activities or enhancement of scope. The certification body shall have documented procedures for the addition of new sites.

5. SAMPLING

5.1. Methodology

5.1.1. The sample should be partly selective

тулгуурлан хэсэгчлэн сонговол зохино, ингэснээр түүврийн санамсаргүй элементийг хасалгүй янз бүрийн салбаруудыг төлөөлөхүйц хүрээг бий болгоно.

based on the factors set out below and partly nonselective, and should result in a representative range of different sites being selected, without excluding the random element of sampling.

5.1.2 Хамгийн багадаа түүвэрлэлтийн 25% нь санамсаргүй байдлаар сонгогдсон байвал зохино.

5.1.2. At least 25% of the sample should be selected at random.

5.1.3 Үлдсэн түүврийг дор дурдсан заалтуудыг харгалзан, сонгогдсон салбаруудын хоорондын ялгаа гэрчилгээний хүчинтэй хугацаанд байж болох хамгийн их байхаар сонговол зохино.

5.1.3. Taking into account the provisions mentioned below, the remainder should be selected so that the differences among the sites selected over the period of validity of the certificate is as large as possible.

5.1.4 Салбаруудыг сонгохдоо доорх зүйлсийг зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

5.1.4. The site selection may include among others the following aspects:

- салбарын дотоод аудит, менежментийн дүн шинжилгээ, сүүлд хийгдсэн баталгаажуулалтын аудитын үр дүн
- гомдлын бүртгэл, залруулах, сэргийлэх арга хэмжээний холбогдох бусад асуудал;
- Салбаруудын хэмжээнд гарсан томоохон өөрчлөлт;
- Төлөв байдал, ажлын журамд гарсан өөрчлөлт;
- Менежментийн тогтолцоо, салбаруудад явагддаг үйл явцын нарийн төвөгтэй байдал
- Сүүлд хийгдсэн баталгаажуулалтын аудитаас хойшхи өөрчлөлт;
- Байгууллагын мэдлэг, менежментийн тогтолцооны төлөвшил
- Results of internal site audits and management reviews or previous certification audits;
- Records of complaints and other relevant aspects of corrective and preventive action;
- Significant variations in the size of the sites;
- Variations in shift patterns and work procedures;
- Complexity of the management system and processes conducted at the sites;
- Modifications since the last certification audit;
- Maturity of the management system and knowledge of the organization;

- Байгаль орчны асуудал, асуудлын цар хүрээ, байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ)-нд үзүүлэх нөлөө;
- Соёл, хэл, захиргааны шаардлагын ялгаа;
- Газар зүйн тархалт
- Environmental issues and extent of aspects and associated impacts for environmental (EMS) management systems;
- Differences in culture, language and regulatory requirements; and
- Geographical dispersion.

5.1.5 Энэ сонголтыг заавал аудитын үйл явц эхлэхэд хийх шаардлагагүй. Төв оффисын аудит дууссаны дараа хийж болно. Аль ч тохиолдолд түүвэрт багтах салбаруудыг төв оффист мэдээлэх ёстой. Үүнийг харьцангуй богино хугацаанд хийх боломжтой ч аудитад бэлтгэх хангалттай хугацаа олговол зохино.

5.1.5. This selection does not have to be done at the start of the audit process. It can also be done once the audit at the central office has been completed. In any case, the central office shall be informed of the sites to be included in the sample. This can be on relatively short notice, but should allow adequate time for preparation for the audit.

5.2 Түүврийн хэмжээ

5.2. Size Of Sample

5.2.1. Баталгаажуулалтын байгууллага олон салбартай байгууллагын аудит болон баталгаажуулалтын нэг хэсэг болох салбаруудыг аудитын үед авах түүврийг тодорхойлох баримтжуулсан журамтай байх ёстой. Тухайн журам нь энэхүү баримт бичигт тодорхойлсон бүх хүчин зүйлийг харгалзан үзвэл зохино.

5.2.1. The certification body shall have a documented procedure for determining the sample to be taken when auditing sites as part of the audits and certification of a multi-site organization. This should take into account all the factors described in this document.

5.2.2 Баталгаажуулалтын байгууллага энэхүү баримт бичгийн дагуу ажиллаж байгаага нотлохын тулд олон-салбарт түүврийг хэрэглэсэн бүртгэлтэй байх ёстой.

5.2.2. The certification body shall have records on each application of multi-site sampling justifying it is operating in accordance with this document.

5.2.3 Дараах тооцоо нь салбар бүрт 50-аас доош ажилтантай, багаас дунд эрсдэл бүхий үйл ажиллагааны жишээн дээр тулгуурласан жишээ юм. Аудитын үеэр хамгийн багадаа хэдэн салбараар зочлох тоо:

5.2.3. The following calculation is an example based on the example of a low to medium risk activity with less than 50 employees at each site. The minimum number of sites to be visited per audit is:

- **Анхны аудит:** түүврийн хэмжээ алс салбарын тооны квадрат язгуур байвал зохино: ($y = \sqrt{x}$), дээд бүхэл тоогоор авна
- **Initial audit:** the size of the sample should be the square root of the number of remote sites: ($y = \sqrt{x}$), rounded to the upper whole number.

- **Магадлах аудит:** Жилийн түүврийн хэмжээ нь алс салбаруудын тооны 0.6 коэффициенттой квадрат язгуур байвал зохино: ($y = 0.6 \sqrt{x}$), дээд бүхэл тоогоор авна
- **Давтан баталгаажуулалтын аудит:** Түүврийн хэмжээ анхны аудиттай ижил байна. Гэхдээ менежментийн тогтолцоо нь гурван жилээс дээш хугацаанд үр нөлөөтэй болохоо нотолсон бол түүврийн хэмжээг 0.8 коэффициентоор багасгаж болно, өөрөөр хэлбэл ($y = 0.8 \sqrt{x}$), дээд бүхэл тоогоор авна.
- **Surveillance audit:** the size of the annual sample should be the square root of the number of remote sites with 0.6 as a coefficient ($y=0.6 \sqrt{x}$), rounded to the upper whole number.
- **Re-certification audit:** the size of the sample should be the same as for an initial audit. Nevertheless, where the management system has proved to be effective over a period of three years, the size of the sample could be reduced by a factor 0.8, i.e.: ($y=0.8 \sqrt{x}$), rounded to the upper whole number.

5.2.4 Баталгаажуулалтын байгууллага менежментийн тогтолцоондоо үйл ажиллагааны эрсдлийн түвшинг дээр заасны дагуу тодорхойлбол зохино

5.2.4. The certification body should define within its management system the risk levels of activities as applied above

5.2.5 Төв оффист анхдагч болон давтан батлагаажуулалт бүрийн үеэр болон жилд багадаа нэг удаа магадлан шалгалтаар аудит хийх ёстой.

5.2.5. The central office shall be audited during every initial certification and recertification audit and at least annually as part of surveillance.

5.2.6 Баталгаажуулалтад хамрагдах менежментийн тогтолцооны үйл ажиллагаанд баталгаажуулалтын байгууллагын хийсэн эрсдлийн шинжилгээгээр нь доорх хүчин зүйлд онцгой нөхцөл байдал байгааг илрүүлвэл түүврийн хэмжээ, давтамжийг ихэсгэвэл зохино:

5.2.6. The size or frequency of the sample should be increased where the certification body's risk analysis of the activity covered by the management system subject to certification indicates special circumstances in respect of factors such as:

- Салбаруудын хэмжээ, ажилчдын тоо (нэг салбарт 50-аас дээш ажилтан);
- Үйл ажиллагааны болон менежментийн тогтолцооны нарийн төвөгтэй байдал, эрсдэлийн түвшин;
- ажлын практикт гарсан өөрчлөлт (ээлжээр ажиллах г.м);
- The size of the sites and number of employees (eg. more than 50 employees on a site);
- The complexity or risk level of the activity and of the management system;
- Variations in working practices (eg. shift working);

- Үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт,
- Асуудлын цар хүрээ, ач холбогдол, байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ)-нд үзүүлэх нөлөө
- гомдол, залруулах, сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлын бүртгэл;
- Үндэстэн дамнасан аливаа асуудлууд;
- Дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээний үр дүн.
- Variations in activities undertaken;
- Significance and extent of aspects and associated impacts for environmental management systems (EMS);
- Records of complaints and other relevant aspects of corrective and preventive action;
- Any multinational aspects; and
- Results of internal audits and management review.

5.2.7 Байгууллага нь салбарын шаталсан тогтолцоотой бол (толгой (төв) оффис, үндэсний оффис, бүс нутгийн оффис, орон нутгийн салбар г.м) дээр дурьдсан анхдагч аудитын түүврийн загварыг түвшин бүрд хэрэглэнэ. Жишээ нь:

1 толгой оффис: аудитын мөчлөг бүрт очно (анхдагч буюу давтан баталгаажуулалт, магадлан шалгалт)
 4 үндэсний оффис: түүвэр = 2: багадаа 1-г санамсаргүй байдлаар,
 27 бүс нутгийн оффис: түүвэр = 6: багадаа 2-г санамсаргүй байдлаар
 1700 орон нутгийн оффис: түүвэр = 42: багадаа 11-г санамсаргүй байдлаар.

5.3 Аудитын хугацаа

5.3.1 Салбар бүрт зарцуулах аудитын хугацаа нь мөн нэгэн чухал элемент бөгөөд баталгаажуулалтын байгууллага олон-салбарт аудит хийхэд зарцуулсан хугацаагаа аудитын хугацааг хуваарилах бодлогын дагуу тайлбарлах чадвартай байх ёстой.

5.3.2 Төв оффис, нэг салбарт зарцуулах хүн өдрийг салбар тус бүрийн хувьд холбогдох стандартын хүн өдрийг тооцох

5.2.7. When the organization has a hierarchical system of branches (e.g. head (central) office, national offices, regional offices, local branches), the sampling model for initial audit as defined above applies to each level. Example:

1 head office: visited at each audit cycle (initial or surveillance or recertification)
 4 National offices: sample = 2: minimum 1 at random
 27 regional offices: sample = 6: minimum 2 at random
 1700 local branches: sample = 42: minimum 11 at random.

5.3. Audit Times

5.3.1. The audit time to spend for each individual site is another important element to consider, and the certification body shall be prepared to justify the time spent on multisite audits in terms of its overall policy for allocation of audit time.

5.3.2. The number of man-days per site, including the central office, should be calculated for each site using the most

тухай хамгийн сүүлийн үеийн IAF баримт бичгийг ашиглан тооцож байх ёстой.

recently published IAF document for the calculation of man days for the relevant standard.

5.3.3 Хасалт хийхдээ төв оффис болон/эсвэл орон нутгийн салбаруудад хамаарахгүй заалтуудыг харгалзан үзэж болно. Ингэж хассан бол үндэслэл шалтгааныг баталгаажуулалтын байгууллага бүртгэлжүүлнэ.

5.3.3. Reductions can be applied to take into account the clauses that are not relevant to the central office and/or the local sites. Reasons for the justification of such reductions shall be recorded by the certification body.

Тайлбар: Хамгийн их буюу чухал үйл явцыг хариуцдаг салбаруудад хасалт хийхгүй (3.0.1-р заалт).

Note: Sites which carry out the most or critical processes are not subject to reductions (clause 3.0.1).

5.3.4 Анхдагч болон магадлан үнэлгээний зарцуулсан нийт хугацаа нь төв оффис, салбар тус бүрт зарцуулсан нийт хугацааны нийлбэр бөгөөд хэрэв бүх ажил нэг салбар дээр (компаний бүх ажилтныг нэг салбар дээр цуглуулж г.м) явагдсан бол үйл ажиллагааны хэмжээ, нарийн төвөгтэй байдлыг үндэслэн тогтоогдох байсан хугацаанаас богино байж болохгүй

5.3.4. The total time expended on initial assessment and surveillance is the total sum of the time spent at each site plus the central office and should never be less than that which would have been calculated for the size and complexity of the operation if all the work had been undertaken at a single site (i.e. with all the employees of the company in the same site).

5.4 Нэмэлт салбар

5.4. Additional Sites

5.4.1 Аль хэдийн баталгаажсан олон-салбарын сүлжээнд нэмэгдэх хүсэлт гаргасан шинэ бүлэг салбаруудын хувьд шинэ бүлэг салбар тус бүрт бие даасан байдлаар түүвэрлэлтийн хэмжээг тодорхойлно. Шинэ бүлгийг гэрчилгээнд нэмсэний дараа шинэ салбаруудын цаашдын магадлан хяналт эсвэл давтан баталгаажуулалтын аудитын түүврийн хэмжээг тодорхойлохын тулд өмнө нь баталгаажсан салбаруудтай нэгтгэнэ.

5.4.1. On the application of a new group of sites to join an already certified multi-site network, each new group of sites should be considered as an independent set for the determination of the sample size. After inclusion of the new group in the certificate, the new sites should be cumulated to the previous ones for determining the sample size for future surveillance or recertification audits.

Энэхүү баримт бичгийн төгсгөл.

End of IAF Mandatory Document for the Certification of Multiple Sites Based on Sampling.

Нэмэлт мэдээлэл

Энэхүү баримт бичгийн талаар болон ОУИФ-н бусад баримт бичгийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл ОУИФ-н гишүүд болон нарийн бичгийн дарга нарын газартай холбогдоно уу.

ОУИФ-н веб сайт - <<http://www.iaf.nu>>

Нарийн бичгийн дарга нарын газар

– Жон Оуэн,

ОУИФ Корпорацийн НБД,

Telephone +612 9481 7343

email <secretary1@iaf.nu>

Further Information

For further Information on this document or other IAF documents, contact any member of IAF or the IAF Secretariat.

For contact details of members of IAF see - IAF Web Site - <<http://www.iaf.nu>> Secretariat

- John Owen,
IAF Corporate Secretary,
Telephone +612 9481 7343
email <secretary1@iaf.nu>